

“Зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ”-нд
өөрчлөлт оруулах тухай

Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.11, Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын даргын 2017 оны А/42 тоот тушаалын хавсралтаар баталсан “Тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд үзүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох журам”-ыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

Нэг. Харилцаа холбооны зохицуулах хорооны 2022 оны 61 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ”-ний “Хүснэгт-1”-д дор заасан өөрчлөлтийг оруулсугай.

- 1.1. №1-ийн Арилжааны радио, телевизийн үйлчилгээ эрхлэх, Арилжааны телевиз, Монгол Улсын нутаг дэвсгэрт “4,500.0 гэснийг 7,700.0” гэж, Улаанбаатарт “2,500.0 гэснийг 4,000.0” гэж, Аймагт “600.0 гэснийг 750,0” гэж, Арилжааны радио, Монгол Улсын нутаг дэвсгэрт “2,500.0 гэснийг 3,900.0” гэж, Улаанбаатарт “800.0 гэснийг 1,400.0” гэж, Аймагт “200.0 гэснийг 300.0” гэж
- 1.2. №4-ийн Олон нийтийн радио, телевизийн үйлчилгээ эрхлэх, Олон нийтийн телевиз “3,000.0 гэснийг 7,900.0” гэж, Олон нийтийн радио “1,500.0 гэнийг 3,900.0” гэж
- 1.3. №5-ын Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэх, Утастай, утасгүй сүлжээгээр олон суваг дамжуулах үйлчилгээ, Монгол Улсын нутаг дэвсгэрт “8,000.0 гэснийг 14,900.0” гэж, Улаанбаатарт “3,500.0 гэснийг 5,500.0” гэж, Аймагт “800.0 гэснийг 1,200.0” гэж
- 1.4. №6-ын Өргөн нэвтрүүлгийн радио, телевизийн үйлчилгээ эрхлэх Өргөн нэвтрүүлгийн телевиз, Монгол Улсын нутаг дэвсгэрт “6,000.0 гэснийг 12,900.0” гэж, Улаанбаатарт “3,000.0 гэснийг 4,300.0” гэж, Аймагт “800.0 гэснийг 1,000.0” гэж, Өргөн нэвтрүүлгийн радио, Монгол Улсын нутаг дэвсгэрт “2,500.0 гэснийг 3,900.0” гэж, Улаанбаатарт “800.0 гэснийг 1,400.0” гэж, Аймагт “200.0 гэснийг 300.0” гэж
- 1.5. №9-ийн Харилцаа холбооны сүлжээ байгуулах, түүнийг ашиглалт үйлчилгээ эрхлэх, Хот, хот хоорондын сүлжээ “15,000.0 гэснийг 39,600.0” гэж, Шуудангийн сүлжээ “3,000.0 гэснийг 25,100.0” гэж
- 1.6. №12-ын Төлбөртэй радио, телевизийн үйлчилгээ эрхлэх, Төлбөртэй телевиз “5,000.0 гэснийг 7,700.0” гэж, Төлбөртэй радио “2,500.0 гэснийг 3,900.0” гэж тус тус өөрчлөх;

Хоёр. Энэхүү тогтоолыг 2025 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.

Гурав. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус Хорооны дарга /Г.Чинзориг /-т үүрэг болгосугай

ДАРГА

Г.ЧИНЗОРИГ